



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД  
ЛУВСАННАМСРАЙН ОЮУН-ЭРДЭНЭ  
ТАНАА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮНИЙ  
АСУУЛТ

14201 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг  
Жанжин Д.Сүхбаатарын талбай 1, Төрийн ордон  
Утас: 26-70-16, Факс: 32-70-16  
E-mail: stategreathural@parliament.mn  
http://www.parliament.mn

2024.08.16 № 11

Боловсролын салбарын багш,  
Ажилтны цалин хөлс, нийгмийн  
баталгааны талаар

2024 оны Улсын Их Хурлын сонгуулийн үр дүнгээр Монгол Ардын Нам, Ардчилсан Нам, ХҮН намын хамтарсан Засгийн газар байгуулагдаж, Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр бусад асуудлыг хэлэлцэхээр ээлжит бус чуулган зарлажээ.

Боловсролын ерөнхий хуулийн 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсэгт “Боловсрол нь хөгжлийн тэргүүлэх салбар байх” тухай заасан ч боловсролын чанар, боловсрол олгож байгаа сургалтын орчин нөхцөл, боловсролын салбарт ажиллаж байгаа багш ажилтнуудын цалин хөлс, нийгмийн баталгаа нь хангалтгүй байгаа бөгөөд үүний нөлөөгөөр улс эх орны болон хүний хөгжил төдий л урагшлахгүй байгаатай хэн ч маргахгүй биз ээ. Иймд боловсролын чанар, хүртээмжийг дээшлүүлэн ажиллах нь энэ засгийн газрын тэргүүлэх зорилтуудын нэг байх ёстой гэж үзэж байна.

Иймд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.1.13 дахь заалт, 37 дугаар зүйлийн 37.1.1 дэх заалт, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Танд дараах асуултыг тавьж байна. Үүнд:

1.2023 оны 9 дүгээр сараас боловсролын салбарын багш, ажилтнуудыг төлөөлж Монголын багш нарын үйлдвэрчний эвлэлийн холбооны зүгээс үндсэн цалинг 1000 доллартой тэнцэхүйц хэмжээнд хүргэх талаар Засгийн газар, Боловсролын яаманд удаа дараа шаардлага хүргүүлж ирсэн. 2024 оны Улсын Их Хурлын сонгуульд өрсөлдөж, өнөөдрийн хамтарсан Засгийн газрыг бүрдүүлж байгаа Монгол Ардын Нам, Ардчилсан Нам, ХҮН намуудын мөрийн хөтөлбөрт ч багш, ажилтны цалин хөлсийг нэмэгдүүлэх талаар тодорхой заалтууд орсон байна. Улс эх орны хөгжлийн тэргүүлэх салбар болох боловсролын салбарын багш, ажилтны үндсэн цалин улсын дундаж цалингаас үлэмж доогуур байгаагаас шалтгаалан олон мянган багш, ажилтан боловсролын салбараас дүрвэж, цалин хөлс өндөр өөр ажилд шилжих, гадаад улс орон руу ажиллах хүчин болж явж эхэлснээр боловсон хүчний хомсдолд ороод байгаа нь нууц биш юм. Хамтарсан Засгийн газрын зүгээс 2024-2028 онд багш, ажилтны үндсэн цалинг (цалингийн доод хэмжээ) хэдэн хувиар нэмэгдүүлж, хэдэн төгрөгт хүргэх зорилт дэвшүүлсэн талаар;

20240812

2.Боловсролын салбарын багш, ажилтнуудаас авсан судалгаанаас үзэхэд 80 гаруй хувь нь хүний амьдралын анхдагч хэрэгцээ болсон орон сууцны нөхцөл нь хүнд байдалтай байгаа нь харагддаг. Үүний үндсэн шалтгаан нь нөгөө л цалин хөлс үнэлэмж доогуур, ипотекийн зээлийн шаардлага нөхцөлийг хангаж чадахгүй байгаатай холбоотой. Олон мянган багш, ажилтнууд орон сууцны нөхцөлөө л сайжруулах гэж өөр ажил руу шилжих, гадаадад гарч байна. Иймд хамтарсан Засгийн газрын зүгээс боловсролын салбарын багш, ажилтнуудыг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцтай болгох тусгай хөтөлбөр гарган хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай байгаа тул 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөртөө хэдэн багш, ажилтныг хөнгөлөлттэй нөхцөлөөр орон сууцтай болгох зорилт дэвшүүлж байгаа тухай;

3.2019 онд Монгол Улсын Ерөнхий сайд У.Хүрэлсүхийн ивээл дор хуралдсан Монголын багш нарын 7 дугаар их хурал, 2024 онд Монгол Улсын Ерөнхийлөгч У.Хүрэлсүхийн ивээл дор хуралдсан Монголын багш нарын 8 дугаар их хурал, Боловсролын ерөнхий хуулийг шинэчлэн батлахад салбарын багш, ажилтнуудаас гаргасан саналуудаас хамгийн өндөр саналтай нь “Багш ажилтны тэтгэвэрт гарах насыг өөрөө хүсвэл эмэгтэй 50, эрэгтэй 55 нас” болгох асуудал байсан. Хамтарсан Засгийн газар энэ асуудлыг хэрхэн шийдвэрлэх тухай;

4.Засгийн газар холбогдох яамдын зүгээс боловсролын салбарын багш, ажилтнуудын ажлын байран дахь хөдөлмөрийн нөхцөл, эрүүл ахуй, аюулгүй байдлын эрсдэл, мэргэжлээс шалтгаалах өвчлөлийг шинжлэх ухааны үндэслэлтэй тогтоож, урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах, эмчлэх үндэсний тогтолцоог бүрдүүлэх чиглэлээр ямар арга хэмжээг авч байгаа талаарх мэдээллийг тус тус ирүүлнэ үү.

Асуултын хариуг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2-т заасан хугацаанд бичгээр ирүүлэхийг хүсье.

УЛСЫН ИХ ХУРЛЫН  
ГИШҮҮН



Ц.МӨНХТУЯА

20240012